

**МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, ГААЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2014 оны 07 дугаар
сарын 28-ний өдөр

Дугаар 4-119/132

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай


Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Гаалийн тухай хуулийн 271 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Монголбанк, Гаалийн ерөнхий газрын хамтран ажиллах журам”-ыг энэхүү тушаалын хавсралтаар шинэчлэн баталсугай.

Хоёр. Журам шинэчлэн баталсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч, Гаалийн Ерөнхий газрын даргын 2008 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 420/607 дугаар хамтарсан тушаал, 2008 оны 11 дүээр сарын 28-ны өдрийн 515/760 дугаар хамтарсан тушаалыг тус тус хүчингүй болгосугай.

Гурав. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Монголбанкны Валют, эдийн засгийн газар /Д.Дэлгэрсайхан/, Гаалийн ерөнхий газрын Статистикийн хэлтэс /Ц.Оюунбилэг/-т тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Хамтарсан тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар /Х.Дэлгэр/, Гаалийн ерөнхий газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ аудитын газар /Н.Сарантуяа/-т тус тус даалгасугай.



126

**МОНГОЛБАНК, ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Монголбанкны Ерөнхийлогч, Гаалийн ерөнхий газрын даргын
2014 оны 07 сарын 28-ны өдрийн ... дугаар
хамтарсан тушаалын хавсралт

УХГ0035

УХИ0014

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Монголбанк, Гаалийн ерөнхий газар (цаашид “Талууд” гэх)-ын хоорондын гадаад худалдаа, валютын урсгал, ханшийн талаарх мэдээлэл солилцоог тогтмолжуулах, Монгол Улсын гааль дээр хураагдсан үнэт зүйлсийг Монгол Улсын Эрдэнэсийн санд хүлээн авах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамтран ажиллах ерөнхий чиглэл

- 2.1 Гадаад худалдаа, ханшийн судалгаа хийх,
- 2.2 Монгол Улсын хилээр орж, гарч буй бэлэн валютын урсгалын судалгаа хийх,
- 2.3 Экспорт, импортын үнийн болон биет хэмжээний индексийг тооцох,
- 2.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийг хэрэгжүүлэх,
- 2.5 Монгол Улсын хил дээр хураагдсан түүх соёлын хосгүй үнэт зүйлсийг “Эрдэнэсийн сан”-д шилжүүлэх,
- 2.6 Мэдээлэл солилцоог цахим хэлбэрт шилжүүлэх.

Гурав. Мэдээлэл солилцох ажлын хурээнд

- 3.1 Монголбанк нь дараах мэдээллийг энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан давтамж, хугацаатайгаар Гаалийн ерөнхий газарт хүргүүлнэ:
- 3.1.1 Төгрөгийн ханшийн мэдээ,
- 3.1.2 Монголбанкнаас гадаадын банк, санхүүгийн байгууллагад худалдсан алтны мэдээ.
- 3.2 Гаалийн ерөнхий газар нь Монголбанкинд дараах мэдээллийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан давтамж, хугацаатайгаар, 3 дугаар хавсралтад заасан үзүүлэлтүүдийн дагуу, үүнээс 3.2.4-т заасан мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд тусгайлан хүргүүлнэ:
- 3.2.1 Гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийн эмхэтгэл,
- 3.2.2 Гадаад худалдааны барааны статистикийн мэдээний бааз,
- 3.2.3 Экспорт, импортын гол 10 нэр төрлийн барааны мэдээллийг аж ахуйн нэгжээр,
- 3.2.4 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол улсын хилээр бэлнээр нэвтрүүлсэн тухай гаалийн мэдүүлгийн мэдээ,
- 3.2.5 Тайлант хугацаанд гааль дээр хураагдсан, “Эрдэнэсийн сангийн тухай” Монгол Улсын хуулийн шаардлага хангасан үнэт зүйлсийн жагсаалт,
- 3.2.6 Импортыг СИФ нөхцөлөөр тооцсон дүнг ФОБ нөхцөл рүү шилжүүлэх коэффициентыг тооцоход шаардлагатай мэдээлэл.

- 4.1 Гаалийн ерөнхий газар нь Монгол Улсын гааль дээр хураагдсан, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Түүх соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг тогтоох мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтээр Эрдэнэсийн санд хадгалах нь зүйтэй гэж үзсэн эрдэнэсийг Монгол Улсын Эрдэнэсийн санг арвижуулах зорилгоор Монголбанкинд шилжүүлж өгнө.

Тав. Бусад зүйл

- 5.1 Талууд энэхүү журамд заасан мэдээг тогтоосон хугацаанд шуурхай гаргаж өгч байх үүрэгтэй.
- 5.2 Нууцын зэрэглэлтэй мэдээллийг холбогдох хууль, эрх зүйн актын дагуу солилцено.
- 5.3 Аж ахуйн нэгж, иргэний гадаад худалдааны талаарх мэдээллийг Монгол Улсын статистикийн тухай хуулийн 22.3 дугаар зүйлд заасны дагуу нийтэд задруулахыг хориглоно. Мөн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасны дагуу мэдээллийг хууль бусаар ашиг олох зорилгоор ашиглахыг хориглоно.
- 5.4 Онцгой тохиолдолд Талууд шаардлагатай мэдээллийг тухай бүр харилцан мэдээлж байна.
- 5.5 Талууд солилцож буй мэдээллийн үнэн зөв, нууцын аюулгүй байдлыг тус бүрдээ хариуцна.
- 5.6 Энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын асуудлыг Талууд тус бүрдээ шийдвэрлэнэ.

--- оОо ---

Монголбанк, Гаалийн өрөнхий
газрын хамтран ажиллах журмын

ХАВСРАЛТ №1

1/132

128

УХГ0035

Монголбанкаас Гаалийн өрөнхий газарт
хүргүүлэх мэдээ, мэдээллийн жагсаалт

1

№	Мэдээлэл	Зорилго	Давтамж	Хугацаа	УХГ0014	Хариуцсан албан ажилтан, харилцах хаяг
					Мэдээллийн хэлбэржилт	
1.	Төгрөгийн ханшийн мэдээ	Гаалийн тооцоонд ашиглах	Өдөр бүр	Өдөр бүрийн 17:30 цаг	Цахим шуудан	Валют, эдийн засгийн газрын СЗЗХ-ийн арилжааны мэргэжилтэн, 322850
2.	Алтны арилжааны мэдээ	Гаалийн мэдээнд тусгах	Сар тутам	Дараа сарын ажлын эхний 3 өдрийн дотор	Цахим шуудан/ Албан тоотоор	Валют, эдийн засгийн газрын ТТССХ-ийн нөөцийн статистик хариуцсан эдийн засагч, 327088

Монголбанк, Гаалийн ерөнхий
газрын хамтран ажиллах жсурмын
ХАВСРАЛТ №2

УХГ0035

Гаалийн ерөнхий газраас Монголбанкинд
хүргүүлэх мэдээ, мэдээллийн жагсаалт

УХГ0014

№	Мэдээлэл	Зорилго	Дав-тамж	Хугацаа	Мэдээллийн хэлбэр-жилт	Хариуцсан ажилтан, харицах хаяг
1.	Гадаад худалдааны барааны статистикийн эмхэтгэл	Ханшийн судалгаа, Төлбөрийн тэнцэл	Сар тутам	Дараа сарын 15-ны дотор	Хэвлэмэл	Статистикийн хэлтэс
2.	Гадаад худалдааны барааны статистикийн мэдээний бааз	Ханшийн судалгаа, гадаад худалдааны индекс, төлбөрийн тэнцэл	Сар тутам, ёссөн дунгээр	Дараа сарын 7-ны дотор	Цахим шуудан	
3.	Экспорт, импортын гол 10 нэр төрлийн барааны гүйцэтгэлийг аж ахуйн нэгжээр	Төлбөрийн тэнцлийн тохируулга	Сар тутам	Дараа сарын 10-ны дотор	Цахим шуудан	Статистикийн хэлтсийн гаалийн улсын байцаагч, 353568
4.	Гадаад худалдааны барааны тээвэр, даатгалын зардлын дэлгэрэнгүй мэдээ	СИФ нөхцөлөөр тооцсон дунг ФОБ нөхцөл РҮҮ шилжүүлэх коэффициент	Жил тутам	Жилийн эцсийн гүйцэтгэл гарсан даруй	Цахим шуудан	
5.	15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол улсын хилээр бэлнээр нэвтрүүлсэн тухай гаалийн мэдүүлгийн мэдээ /барааны мэдүүлэг болон зорчигчийн деклараци/	Бэлэн валютын урсгалын мэдээлэл	Сар тутам	Дараа сарын 10-ны дотор	Цахим шуудан	Статистикийн хэлтсийн гаалийн улсын байцаагч, 353568
6	Хураагдсан зүйлсийн жагсаалт	Эрдэнэсийн санг баяжуулах	Сар тутам	Дараа жилийн эхний улиралд багтаан	Албан тоот	Гаалийн хэрэг зөрчилтэй тэмцэх хэлтсийн ГУБ

1/132

(30)

Гаалийн ерөнхий газраас Монголбанкийн
хүргүүлэх мэдээ, мэдээлэлд хамрагдах үзүүлэлтүүд

УХИ0014

УХГ0035

Гадаад худалдааны барааны статистикийн мэдээний баазыг дараах үзүүлэлтүүдээр:

- Экспорт, импортыг тодорхойлсон талбар
- Хугацаа, сараар
- Барааны ангиллын код 4 орны түвшинд
- Барааны ангиллын код 8 орны түвшинд
- Валютын төрөл
- Барааг хүлээн авагч улс
- Барааны гарал үүслийн улс
- Тээврийн төрлийн код
- Хэлцлийн код
- Тоо хэмжээ
- Хэмжих нэгж
- Үнийн дүн

Экспорт, импортын гол 10 нэр төрлийн барааны¹ гүйцэтгэлийг аж ахуйн нэгжээр авах мэдээллийг дараах үзүүлэлтүүдээр:

- Огноо
- Илгээгчийн регистр, нэр
- Хүлээн авагчийн регистр, нэр
- Бараа нийлүүлэх нөхцөл
- Хэлцлийн код
- Хүлээн авагч улсын код /экспорт/
- Гарал үүслийн улсын код /импорт/
- Хил дээрхи тээврийн хэрэгслийн код
- Барааны код, нэр /4 орноор/
- Хэмжих нэгж
- Тоо хэмжээ
- Валютын код, ерөнхий дүн
- Мэдүүлгийн дугаар
- Бараа дэс дугаар
- Тээврийн зардал
- Даатгалын зардал
- Нэмэгдэх зардал
- Үнийн дүн, ам.доллар

¹ Экспорт: Чулуун нүүрс (2701), Зэсийн баяжмал (2603), Төмрийн хүдэр ба баяжмал (2601), Боловсруулаагүй нефть (2709), Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт (7108), Цайрын хүдэр ба баяжмал (2608), Молибдений хүдэр ба баяжмал (2613), Жонш, лейцит, нефелинит ба нефелинит сиенит (2529), Ямааны угаасан ноолуур (5102), Ямааны самнасан ноолуур (5105)

Импорт: Нефтийн бүтээгдэхүүн (2710), Суудлын машин (8703), Ачааны машин (8704), Бульдозер, авто хусуур, хамагч зэрэг (8429), Шороо, чулуу ялгах, шигшэх, таллах машин механизм (8474), Цахилгаан эрчим хүч (2716), Өргөгч, ачигчэргийнэданги (8431), Цемент (2523), Хар металлан эдлэл (7308), Халуунаар цувиж, давтаж, мушгисан, чанаржуулаагүй гангаар хийсэн бусад цулдан ба туйван (7214)

Гадаад худалдааны барааны тээвэр, даатгалын зардлын дэлгэрэнгүй мэдээг дараах үзүүлэлтээр:

- Огноо
- Мэдүүлгийн дугаар
- Бараа нийлүүлэх нөхцөл
- Валютын код,
- Үнийн дүн тухайн валютаар
- Тээврийн зардал
- Даатгалын зарда
- Нэмэгдэх зардал
- Ханш
- Үнийн дүн, ам.доллар
- Барааг илгээгч улсын код
- Хил дээрхи тээврийн хэрэгслийн код
- Барааны код, нэр /8 орноор/
- Хэмжих нэгж
- Тоо хэмжээ

131

15 саяас дээши төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол улсын хилээр бэлнээр нэвтрүүлсэн тухай гаалийн мэдүүлгийн мэдээг /барааны мэдүүлэг болон зорчигчийн гаалийн мэдүүлэг / дараах үзүүлэлтүүдээр:

Зорчигчийн мэдээлэл

- Огноо
- Орох, гарах эсэх
- Бoomтын нэр
- Зорчигчийн овог нэр
- Зорчигчийн регистрийн дугаар
- Зорчигчийн харьяалал
- Зорчигчийн аяллын чиглэл
- Зорчигчийн маршрут
- Валютын төрөл
- Валютын тоо хэмжээ
- Валютын зориулалт

ААН-ийн мэдээлэл

- Экспорт, импорт
- Горимын код
- Хэлцлийн код
- Регистрийн дугаар
- ААН-ийн нэр
- Гарал үүсэл
- Экспорт/Импортын улс
- Барааны код
- Барааны оноосон нэр
- Барааны марк
- Барааны зориулалт
- Нэгж үнэ
- Тоо хэмжээ
- Хэмжих нэгж
- Үнийн дүн, доллар
- Үнийн дүн, төгрөг